

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
6-Р АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хугацаа: 40 минут

“А” ВАРИАНТ

Нийт оноо 32

Сурагчийн нэр анги

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: /15 даалгавар 20 оноотой./

1. Шүдээ өдөрт дор хаяж хэдэн удаа угаах ёстой бэ? /1 оноо/
A. 1 удаа B. 2-3 удаа C. 4-5 удаа D. 5-с дээш удаа
2. Гэдэсний халдварт өвчин юунаас халдварлах вэ? /1 оноо/
A. Гэдэсний халдвартай хүнээс
B. Буруу хадгалсан хоол хүнснээс
C. Бохир гарнаас
D. Дээрх бүгд
3. Хоолоор авах хоногийн илчлэгээ хэтрүүлэн хэрэглэвэл /1 оноо/
A. Жиндээ хүрнэ B. Таргалалт үүснэ
C. Турахад хүрнэ D. Хэвийн байна
4. Эмийг зөвхөн өвдсөн үед ууж хэрэглэнэ. /1 оноо /
A. Эмчийн бичсэн жорын дагуу B. Ээжийнхээ зөвлөсний дагуу
C. Найзынхаа хэлсэн зөвлөсний дагуу D. эмээгийн зөвлөсний дагуу
5. Эерэг зөв харилцаатай хүн гэж ямар хүнийг хэлэх бэ? /2 оноо/
A. Бусдыг хүндэлдэг B. Аливаа асуудалд хүлээцтэй ханддаг
C. Уучилж чаддаг D. Бүгд
6. Сойзыг хэрхэн зөв сонгох вэ? /2 оноо/
A. Өөрийнхөө үүдэн хоёр шүдний өргөнтэй тэнцүү хэмжээтэй
B. Насандаа тохирсон
C. Өөрийнхөө араа шүдтэй тэнцүү хэмжээтэй
D. Ямар ч байж болно
7. Чи гараа ямар үед угаах шаардлагатай бэ? /1 оноо /
A. Бие зассаны дараа, хоол идэхийн өмнө
B. Гаднаас орж ирээд, бохирдогдсон тухай бүрд нь
C. А болон В
D. Цаг тутамд угаах
8. Хүүхэд өсвөр үеийнхэн ямар төрлийн хоол хүнс хэрэглэх хэрэгтэй бэ? /1 оноо/
A. Сүү цагаан идээ, мах хүнсний ногоо
B. Өөх тос ихтэй шим тэжээлтэй хоол
C. чихэрлэг хоол хүнс, жимс жимсгэнэ
D. Түргэн хоол, ундаа чихэр
9. Дасгал хөдөлгөөн хийх үедээ ямар хувцас өмсөх хэрэгтэй вэ? /1 оноо/
A. Биеийн тамирын хувцас B. Дүрэмт хувцас

С. Гоёлын хувцас

Д. Бүгд зөв

10. Тухайн агшинд хүн ямар нэгэн зүйлийг хүртэхүйн эрхтэнээр хүлээж авахад төрж байгаа сэтгэгдлийг /2 оноо/

А. Сайхан гэдэг В. Уурлах гэдэг С. Мэдрэмж гэдэг Д. Бодол гэдэг

11. Хэн нэгэнтэй харилцахдаа байвал зохих хэм хэмжээг баримталбал харилцаа болно. /1 оноо/

А. энгийн В. эрүүл бус С. эрүүл Д. Зөрчилтэй

12. Тээврийн хэрэгслээр зорчихдоо аюулгүйн журам зааврыг зөрчвөл яах бэ? /2 оноо/

А. Асуудал үүсэхгүй В. Осол гэмтэл гарахгүй

С. Эрүүл саруул байна. Д. Осол аюулд өртөнө.

13. Дотуур хувцас нь ямар материалаар хийгдсэн байх нь эрүүл ахуйн хувьд сайн байх бэ? /1 оноо/

А. Хөвөн даавуун материалтай В. Хагас нейлонон материалтай

С. Бүтэн нейлонон материалтай Д. Цэвэр даавуун материалтай

14. Цахим тоглоомыг хэдэн цагаас илүү хэрэглэвэл “хэтрүүлэн хэрэглэлт” гэж үздэг бэ? /2 оноо/






А. 4 цаг В. 2 цаг С. 6 цаг Д. 7 цаг

15. Эмийн тухай мэдээллийг хэнээс авч болох бэ? /1 оноо /

А. Сонин сэтгүүлээс В. Багшаас С. Эмчээс Д. Эмийн санчаас

ХОЁР ДУГААР ХЭСЭГ-ЗАДГАЙ ДААЛГАВАР /4 даалгавартай 12 оноотой/

1. Зурагт өгөгдсөн эмийн хэлбэрүүдийг тодорхойлж харгалзах нүдэнд нөхөж бичнэ үү. /3 оноо/



2. Шүд ямар үүрэгтэй вэ? Тайлбарлаж бичнэ үү?

/2 оноо/

.....

.....

.....

3. Уураа илэрхийлэх аргуудын эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлно уу? /3 оноо/

Уураа илэрхийлж буй байдал	Эерэг үр дагавар	Сөрөг үр дагавар
Хашхирах, үгээр доромжлох, хаалга савах, юм авч шидэх, цохих		
Өөрийгөө буруутгаж, үзэн ядаж байна гэж өөртөө хэлэх, хоол ундаа идэхгүй байх, өөрийгөө хохироох, үгүйсгэх		
Дуугаа хураах, хэнтэй ч ярихгүй байх, юу ч хэлсэн үл тоох, татгалзах, өгсөн үүрэг даалгаврыг хийхгүй байх дүнсгэр байх		

4. Цахим хэрэгслийг хэрхэн хэтрүүлэн хэрэглэхээс татгалзах вэ?

/4оноо/

А.....

Б.....

В.....

Г.....

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
6-Р АНГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хугацаа: 40 минут

“В” ВАРИАНТ

Нийт оноо 32

Сурагчийн нэр анги

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: /15 даалгавар 20 оноотой./

1. Чихэр болон чихэрлэг бүтээгдэхүүн хэрэглэсний дараа хэрхэн шүд, цоорлоос сэргийлэх бэ? /1 оноо/
A. 30 минут дотор шүдээ угаах боломжгүй бол амаа усаар зайлна.
B. 20 минут дотор шүдээ угаана .
C. 15 минут дотор угаах эсвэл цай уух
D. 5 минут дотор угаана.
2. Түгээмэл тохиолддог гэдэсний халдварт өвчин аль нь бэ? /1 оноо/
A. Цагаан хорхой, цусан суулга, халдварт шар
B. Ханиад томуу
C. Хоолны хордлого
D. Вируст гепатит
3. Хоол тэжээлийн дутагдал юунаас үүсэх бэ? /1 оноо/
A. бага идсэнээс
B. зохисгүй хооллосноос
C. ядарч сульдсанаас
D. амин дэм багатай хүнс хэрэглэснээс
4. Аливаа өвчин эмгэгийг эмчлэх зориулалттай эмчилгээний үр нөлөө нь судалгаагаар бүрэн нотлогдсон, тухайн орц найрлагын дагуу химийн аргаар үйлдвэрлэсэн бэлдмэлийг хэлнэ. /1 оноо/
A. Аминдэм
B. тариа
C. эм
D. дусал
5. Хэн нэгэнтэй харилцахдаа байвал зохих хэм хэмжээг хэтрүүлсэн, зөрчсөн харилцаагхарилцаа гэнэ. /2 оноо/
A. эрүүл
B. энгийн
C. эрх дураараа
D. эрүүл бус
6. Шүдээ угаахдаа сойзон дээрээ оог ямар хэмжээтэй түрхэх бэ? /2 оноо/
A. Чигчий хурууны хумсны толион чинээ
B. Эрхий хурууны хумсны толион чинээ
C. Сойз дүүрэн түрхэнэ.
D. Сойзны үзүүр дээр л түрхэнэ
7. Гэдэсний халдвар дамжих замыг нэрлэ. /1 оноо/
A. Удсан хоол хүнс
B. Агаар дусал
C. Бохир гар
D. Арьс салст
8. Хоол тэжээлийн дутагдлын хор уршиг юу бэ? /1 оноо/
A. Өсөлт хөгжилт удааширна
B. Дархлаа суларна
C. Оюун ухааны хоцрогдол
D. Бүгд зөв
9. Долоо хоногт 3-5 удаа дасгал хөдөлгөөн тогтмол хийх нь ач тустай

- A. Эрүүл мэнд B. Хичээлээ сайн хийхэд C. Өсөлт хөгжил /1 оноо/
D. Бүгд зөв
10. Үгийг нөхөөрэй. /2 оноо/
..... нь сэрэг бодол, сэрэг үг, сэрэг үйлдлээс үүдэлтэй .
A. хүндэтгэл B. хайр C. уур D. түргэн зан
11. Эрүүл бус харилцааны шинжийг ол. / 1 оноо/
A. ярилцах B. хүндлэх C. санал бодлоо тулгах D. Хайрлах
12. Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэлд юу юу орж болох бэ? /2 оноо/
A. хүчтэй шороон шуурга B. цасан шуурга
C. үер аянга цахилгаан D. Бүгд
13. Зуны улиралд дотуур хувцас нэн тохиромжтой /1 оноо/
A. Хөвөн B. Даавуун C. Торон D. Ноосон
14. PC тоглоомд донтсоноос үүссэн сэрэг нөлөөг ол. /2 оноо/
A. хичээлдээ муудна B. хараа муудна C. цаг алдана D. бүгд зөв
15. Хэрэв эмийг эмийн сангаас авсан тохиолдолд хамгийн түрүүнд юуг нь харах ёстой бэ? /1 оноо/
A. Найрлага харна B. Үнэрийг үнэрлэнэ
C. Тунадас харна D. Хугацааг харна

ХОЁР ДУГААР ХЭСЭГ-ЗАДГАЙ ДААЛГАВАР /4 даалгавар 12 оноотой./

1. Эмийн сангаас эм худалдан авахад анхаарах зүйлсийг хүснэгтэд өгөв.
Шалтгааныг талбайрлаж бичнэ үү? / 3 оноо/

Эмийг худалдан авахдаа анхаарах зүйлс	Шалтгаан
Эмийн хадгалах нөхцөл	
Үйлдвэрлэсэн он,сар,өдөр	
Эмийг хэрэглэх заавар	

2. Нөхөж бичнэ үү?

/2 оноо/

№	Шүд, амны хөндийн өвчнүүд	Илрэх шинж тэмдэг	Авах арга хэмжээ
1	Шүд цооролт		
2	Буйлны өвчин		
3	Амны гэмтэл		

3. Мэдрэмж болон сэтгэл хөдлөлийн ялгааг тайлбарлан бичнэ үү? /3 оноо/

.....

.....

.....

.....

.....

4. Цахим хэрэгслийн давуу талыг жишээ гарган бичнэ үү?

/4 оноо/

А.....

Б.....

В.....

Г.....

ХАРИУЛТ БА ОНООНЫ СХЕМ

Даалгаврын дугаар	А хувилбарын зөв хариулт	Б.Хувилбарын зөв хариулт	Оноо
Нэгдүгээр хэсэг			
1	В	D	1
2	С	A	1
3	В	D	1
4	A	С	1
5	D	D	2
6	A	A	2
7	С	С	1
8	A	D	1
9	A	D	1
10	С	С	2
11	С	С	1
12	D	D	2
13	D	В	1
14	В	D	2
15	С	D	1
			20
Хоёрдугаар хэсэг			
1	1. Шахмал эм 2. Капсул эм 3. Үрлэн эм 4. Тосон түрхлэг 5. Лаа 6.Уусмал –	- Хадгалтын горим алдагдах - Хугацаа нь дууссан бүтээгдэхүүн хүний биед сөрөг нөлөөтэй - Тогтсон зааврын дагуу үр дүнтэй хэрэглэх	Нийт 3 оноо
	тус бүр 0.5 оноо	- Хариулт бүр 1 оноо	
2	- Хоол хүнс идэх, бутлах - Хэл ярианд оролцох - Нүүр царай гоо сайхан эрүүл мэндийн байдлыг илэрхийлэх	- шүд өвдөх цоорсон шүд мэдрэмтгий болох нүдэнд харагдахуйц цооролт бий болох - Буйл хавдах Буйл тод улаан өнгөтэй болох амнаас эвгүй үнэр гарах - халуурах бөөлжих хоолонд дургүй болох	Нийт 2 оноо
	- Зөв хариулт бүр 1 оноо	6 хариулт бичих – зөв хариулт бүр 0.34	
3	Эерэг үр дагавар байхгүй, Сөрөг дагавар - Бусдыг гомдоох өөрөө бэртэж гэмтэх сэтгэл санааны хямралд орох Дархлаа муудах гэх мэт	Мэдрэмж гэдэг нь хүн тухайн агшинд ямар нэг зүйлийг хүртэйхүйн аль нэг эрхтнээрээ хүлээн авч тусгасныхаа дараа төрж байгаа сэтгэгдэл юм. Харин сэтгэл хөдлөл аливаа зүйлд хандах дотоод сэтгэлийн илрэл	3
	6 хариулт бичих – зөв хариулт бүр 0.5	Зөв тодорхойлолт бүр 1.5 оноо	
4	Цахим хэрэгслийг зохих цагийн хуваарийн дагуу насанд хүрсэн хүний хараа хяналтан дор хэрэглэх	-	4
	Хариулт бүр 1 оноо	- Хариулт бүр 1 оноо	
		НИЙТ ОНОО	32